



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/64

Батширээт сум

Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дахь хэсгүүд, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны А/125 дугаар тушаал, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/26 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажилд сумын хэмжээний бүх үхэр, сарлагийг хамруулж 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд чанартай зохион байгуулж, гүйцэтгэх болон туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчилга өгч ажиллахыг "Баянбараат хайрхан"ХХК-ийн захирал (Т.Бямбадорж), "Шүтээн дэнж"ХХК-ийн захирал (Б.Мягмаржав), "Өглөгч сүрэг"ХХК-ийн захирал (Ц.Ариунболд) нарт тус тус үүрэг болгосугай.
2. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч бүрэн хамруулж, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд, малчдыг татан оролцуулж мэдээлэл хүргэн, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Ж.Ундрах)-д үүрэг болгосугай.
4. Уг ажилд хүн хүчээр хангаж, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэн ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501127